

**“УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН АНГИЛЛЫГ ШИНЭЧЛЭН
ТОГТООХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН 1995 ОНЫ 26 ДУГААР ТОГТООЛД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”-ийн 3.4-т “Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ”, Монгол Улсын Их Хурлын 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-ын 3.2.1-д “байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувьд хүргэх”, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл баримтлал-2030”-ын 2.3.1-д “Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах...” хэмээн тодорхойлсон төрийн бодлого зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах газар нутгийг улсын байгалийн нөөц газарт хамруулахаар судалгаа хийж, үндэслэлийг боловсруулав. Үүнд:

Архангай аймгийн Жаргалант, Тариат, Өндөр-Улаан сумдын нутаг дахь “Далтын нуруу, Шаргачны голын ай сав”-ын зарим хэсгийг хамруулан байгалийн нөөц газарт хамруулах талаар тогтоолын төсөлд тусгана.

Өндөр-Улаан сумын Азарга багийн Шаргачин гол дагуу Далтын нуруу орчим ураны орд байдаг бөгөөд уг ордын нөөцийн хувьд зүүн хойд талаараа Жаргалант сумын Асайт багт 10 хувь, баруун хойд талаараа Тариатын Мөрөн, Алтаад багт 10 хувь, Өндөр-Улааны Азарга багт 80 хувь тус тус хамаардаг байна. Үүнтэй холбогдуулан ашигт малтмал хайх, олборлох, байгалийн унаган төрхийг өөрчлөх, голын ус бохирдуулах зэрэг сөрөг үр дагавар гарч нутгийн оршин суугчдын эрх ашгийг хөндөж болзошгүй нөхцөл байдал бий болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Мөн Архангай аймгийн Жаргалант, Чулуут, Өндөр-Улаан сумдын зарим хэсгийг байгалийн нөөц газарт хамруулснаар байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, эртний түүхийн ул мөрийг хадгалсан газрыг хойч үедээ өвлүүлэн үлдээх, аялал жуулчлалын түшиц газар болгон хөгжүүлэх боломжтой.

Дээрх газрыг улсын байгалийн нөөц газрын сүлжээнд хамруулснаар газар нутгийн талбайн хэмжээ 54766 га орчим талбайгаар нэмэгдэнэ. Тус газарт үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын зөвшөөрөл байхгүй болно. Тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсөвт ямар нэгэн нэмэлт зардал үүсэхгүй.

Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд тогтоол батлагдсантай холбогдуулан “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт оруулахаар тогтоолын төсөлд тусгасан.

---000---